

## ӨГҮҮЛЭЛ

**Монгол Улсын тав дахь  
Ерөнхийлөгч Х.Баттулгын гадаад бодлого,  
түүний онцлог**

*Дашдоржийн Баярхүү*

*Гадаад бодлогын эксперт, судлаач-профессор, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд  
bayardevi@hotmail.com*

**Хураангуй:** Энэхүү өгүүллийг албаа өгсөн ноён Х.Баттулгад зориулаагүй, түүний халааг авч буй зургаа дахь Ерөнхийлөгч ноён У.Хүрэлсүх болон түүний өнгөн дээр ажиллах Засгийн газар, ялангуяа ГХЯ-нд зориулж бичсэнийг ойлгон хүлээн авах биз ээ. Ноён Х.Баттулга дөрвөн жил ажиллахдаа Монгол Төрийн гадаад бодлогыг зөв, оновчтой, зарим талаар хэмнэлттэй үргэлжлүүлсэн гэдгийг дор баримтаар дэлгэрэнгүй өгүүллээ. Тэнцвэрийг хаа хаанаа зөв барьж чадсан гэж үзлээ. Монгол Улсын гадаад бодлого залгамж шинжтэй, зөв эхлэлийг зөв өвлөх гэдэг утгаар дараагийн шинэ Төрийн тэргүүн, түүний Тамгын газарт энэхүү өгүүлэл хүрэх болтугай!

**Зангилаа үгс:** Монгол Улсын Ерөнхийлөгч, Х.Баттулга, гадаад бодлого, олон талт форумыг гадаад харилцаанд ашиглахуй

### Оршил

Монгол Улс бол ардчилсан тогтолцоотой, парламентын засаглалтай, Ерөнхийлөгчөө бүх ард түмнээрээ сонгодог, ардчилал нь нийгмийн баялаг–баталгаа болчихсон, хүний эрх эрх чөлөөг дээдэлдэг орон билээ. Ийм түүхэн замналаар даруй 31 дэх жилдээ замнаж байна.

Монгол Улс бол нээлттэй улс төрийн тогтолцоо, эрх зүйт төр,

хариуцлагатай засаглалыг эрхэмлэдэг, байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийн гарцыг эрэлхийлдэг, эдийн засагтаа олон тулгуурт бүтэц буй болгох, дэд бүтцээ хөгжүүлэх, тэгснээрээ ард түмнээ амар жимэр, баялаг хангалуун амьдруулахад хүчин чармайлт тавьж ирсэн улс юм.

Монгол бол мөнхийн хоёр хөрштэйгээ эвсэг найрсаг хамтын



ажиллагааг бүхий л талаар өргөжүүлэн хөгжүүлэхийг эрмэлзэж ирсэн, тэр байр суурь бодлогодоо үнэнч байдаг, бас олон тулгуурт гадаад бодлого хэр чинээндээ явуулдаг, тэр хүрээнд гуравдагч хөршүүдийг ямагт эрэлхийлж, хамтран ажиллахыг зорьж ирсэн улс билээ.

Ийм дэвсгэр дээр Монгол Төрийн тэргүүний гадаад бодлогыг үнэлж дүгнэх ёстой юм. Өмнөх дөрвөн Ерөнхийлөгчийн гадаад бодлого ямар зам туулж, ямар амжилтад хүрсэн, түүнийг баяжуулж, төгөлдөршүүлж, гадаад харилцааны асар их боломжийг дотоодынхоо хөгжил дэвшилд оновчтой ашиглах нь тав дахь Ерөнхийлөгчийн гадаад бодлого байх ёстой байсан болов уу.

Тав дахь Ерөнхийлөгч бол 2016 онд УИХ-ын сонгуульд ялагдсан, УИХ-ын гадна (хэрэг дээрээ улс төрийн тогооны гадна) байж байгаад Ерөнхийлөгчийн сонгуульд ялсан анхны тохиолдлын Ерөнхийлөгч юм. Тэр утгаар ажил хэргээс холдсон байх болов уу гэтэл сонгогдсон тэр мөчөөсөө гадаад бодлого, гадаад харилцаандаа түүртэлгүй орсон.

Монгол хүний хувийн араншин, сэтгэхүй нь ажил алба, бодлогод ямагт тусгалаа олж ирсэн нийтлэг (Монгол бүх улс төрчид тохиолддог нийтлэг үзэгдэл) дутагдлаас тав дахь Ерөнхийлөгч тойрч гараагүй нь мэдээж боловч өмнөх дөрөв дэх Ерөнхийлөгчийн 8 жилийн гадаад бодлогын ололтуудыг шат ахиулсан, олон талтай болгосон, өвөрмөц арга барил гадаад бодлогод хэрэгжүүлэхийг зорьсон алхмууд хийснийг тэмдэглэх нь зөв биз ээ.

Дэлхий дахины цар тахлын эрсдлийн амаргүй жил хагасыг оруулж тооцоод тав дахь Ерөнхийлөгч нь чамлахааргүй ажлыг гадаад харилцааны салбарт амжуулжээ. 2017-2021 онд тав дахь Ерөнхийлөгчийн өнгөн дээр гадаадад хийх айлчлал, гадаадаас хүлээж авах дээд өндөр хэмжээний төлөөлөгчдийн тоо харьцангуй бага гарч байна. Тэрээр гадаадад айлчилсан байдал нь ингэж жагсана. Үүнд 2017 онд Жүдо бөхийн насанд хүрэгчдийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн (Унгар, Будапешт), Дорнын эдийн засгийн III чуулга уулзалт (Владивосток); 2018 онд ШХАБ-ын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн XVIII хуралдаан (Циндао, БНХАУ), Дорнын эдийн засгийн IV чуулга уулзалт (Владивосток), Жүдо бөхийн насанд хүрэгчдийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн (Азербайжан, Баку), АСЕМ-ын дээд хэмжээний XII уулзалт (Брюссель), Дэлхийн хөрөнгө оруулалтын чуулга уулзалт (Женев); 2019 онд БНХАУ-д айлчлал, “Бүс ба Зам” олон улсын хамтын ажиллагааны форумын II уулзалт (Бээжин), Киргизстанд айлчлал, ШХАБ-ын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн XIX хуралдаан (Бишкек, Киргизстан), АНУ-д айлчлал, Дорнын эдийн засгийн V чуулга уулзалт (Владивосток), БНЭУ-д айлчлал; 2020 онд Давос хотноо Дэлхийн эдийн засгийн 50 дугаар чуулга уулзалт, Норвегийн Хаант Улсад айлчлал, БНХАУ-д айлчлал (коронавирүсийн эсрэг “Гучин мянган хонины дипломат” санаачилга) гэсэн жагсаалт гарч байна. Хариуд нь гадаадаас урьж

айлчлуулсан нь ганцхан буюу ОХУ-ын Ерөнхийлөгчийг 2019 онд урьж айлчлуулсан дүнтэй байна.

Анхлан АСЕМ-ын дээд хэмжээний XI уулзалтад (Улаанбаатар, 2016 он) айхтар шүүмжлэлтэй хандаж, түүний санхүүгийн гарлага зарлагыг тооцуулж, Монголын ядууралд ямар нэмэртэй юм гэсэн байдлаар хандаж, Улаанбаатарын уулзалтыг үгүйсгэх хандлагатай байснаа дараагийн XII уулзалтад (Брюссель) биечлэн

очиж оролцсон нь логик талаасаа ойлгомжгүй гэж гадаадынханд төсөөлөгдсөн байж болно. Харин нэг том дэвшил бол ардын дипломатын (жүдо бөх, “Гучин мянган хонь” гэх мэт) аргыг Төрийн гадаад бодлогод овжин хэрэглэж, хоёр хөрш орны удирдагчидтай хэл амаа амархан ойлголцож, Владивостокийн эдийн засгийн форумд гурван жил дараалан оролцож, тэнд олон талт дипломатын бодлого явуулж чадсан явдал юм.

### Нэг. Технократ гадаад бодлого

Тав дахь Ерөнхийлөгч хэн байв, ер нь хэн бэ гэдэгт энэ дэд гарчиг онох болов уу. Үүнд олон тайлбар хэрэггүй. Юу гэвэл өнөөдөр Монголд хувийн хэвшил дотоодын нийт бүтээгдэхүүний 80 гаруй хувийг бүрдүүлэн, эдийн засгийн гол хөдөлгөгч хүч нь болж байна. Харин тав дахь Ерөнхийлөгч бол бизнес эрхлэгчийн хувьд 1990 оны эдийн засгийн хүнд шилжилтийн үеэс ганзагын худалдаачнаас үйлдвэрийн захирал хүртэлх зам туулах явцдаа Орос, Хятадын бизнес эрхлэгчидтэй нягт хамтарч ажиллаж байсан туршлагатай, бас УИХ-д гурван удаа сонгогдож, Монгол Улсын Засгийн газарт хоёр удаа сайдаар томилогдон ажилласан хүн гэдгээс “технократ” гэх тодотгол хийгдэнэ.

Түүний хэлсэн үгэнд ч үе үе цухалздаг. Юу гэвэл хоёр хөрштэйгээ хамтын ажиллагаа хөгжүүлэхдээ улс төрийн яриа хэлэлцээ, дээд хэмжээний айлчлалын давтамжаас илүүтэй яг бодитой ямар ажил вэ, тэр нь ард түмэнд бодитой үр дүнгээ өгөх үү

гэдгийг онцлох, эсвэл гуравдагч хөршүүд дээр авч яривал Монголын ардчиллын ололт, туршлагыг олон улсад сурталчлах, ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг гэхээсээ илүүтэй өндөр хөгжилтэй өрнө-дорнын гуравдагч хөршүүдтэй тогтоосон харилцаанаас Монголын ард түмэнд биетэй бодитой нялзах юм юу байх вэ гэдэгт ач холбогдол өгөх, үүнийг л би “технократ гадаад бодлого” хэмээн төсөөлөөд байгаа юм.

Түүний хэлсэн үгс байна. Олон жил яриа хэлцлийн түвшинд өрнөсөн гурван улсын хамтын ажиллагаанаас бодит үр дүн, хэрэгжилтийг Монголын ард түмэн хүлээж байгаа. Тийм учраас бодит хэрэгжилтийн төлөө миний бие эрхэм Ши Жиньпин дарга, эрхэм В.В.Путин Ерөнхийлөгч нартай ойр дотно, идэвхтэй хамтран ажиллах эрмэлзэл дүүрэн байна. Энэ зорилтын төлөө байнгын холбоотой, хугацаатай, уялдаатай ажиллах хатуу үүргийг гурван улсын холбогдох байгууллагуудад өгч,

шуурхай хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллахыг санал болгож байна<sup>1</sup> хэмээн тэрээр 2018 онд ярьж байсан.

Монголын зардаг борлуулдаг түүхий эд, бүтээгдэхүүнд боломжийн хэрээр нэмүү өртөг шингээж технологийн хувьд шинэчилнэ, дэлхий сонирхдог хоёр том зах зээл рүүгээ экспорт хийнэ гэсэн хатуу бодолтойгоор тэрээр иржээ. Гадаад харилцааны асар их боломж эдийн засагт тусгалаа олохгүй, ажилгүйдэл ядууралд нэмэр болохгүй байна, Монголын эдийн засаг үхээнц байна гэдэг хатуу шүүмжлэлтэй тэрээр өнгөрсөн дөрвөн жилд Төр тэргүүлснийг нийтээрээ мэднэ. Эдийн засгийн ямар л гарц, боломж байна, түүнийг хайж ажилласан, гадаад бодлогоос үзэл суртлыг (ардчилал, хүний эрх эрх чөлөө гэх мэт) түр холдуулсан тийм бодлогыг явуулжээ.

Мөн эдийн засгийн харилцааг сайжруулах тал дээр бодит алхмууд хийхээр бодлогоо төвлөрүүлэв. Жишээ нь, гааль, худалдааны тариф дээр гадагшаа хандуулж ахиц дэвшил авчрах зорилго тавьсан. Эдийн засгийн бүхий л салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих байр сууриа сулруулаагүй. Манай улсын татварын хувь хэмжээ Ази-Номхон далайн бүс нутгийн бусад орнуудын татварын хувь хэмжээтэй харьцуулахад харьцангуй бага түвшинтэйд тооцогддог, тухайлбал гаалийн татвар 5 хувь, НӨАТ 10 хувь, аж

ахуйн нэгжийн орлогын албан татвар 10 болон 25 гэсэн шатлалтайгаар мөрдөгддөг, харин түүний давуу талыг муу ашиглаж байгааг гадаад эдийн засгийн хамтын ажиллагаандаа засаж залуурна хэмээн тэрээр ярьсаар ирсэн.

Түүний анхны ярилцлага мэдэгдлүүдэд ийм санаа туссан байв. Юу гэвэл 1990 он хүртэл манай урд хил хаалттай, зөвхөн хойшоо харж хойд хөрштэйгөө харилцдаг байлаа. Гэтэл өнгөрсөн 27 жилийн (2017 оны байдлаар) хугацаанд хойд хөрштэйгээ бараг эдийн засгийн харилцаагүй болчихсон. Урагшаагаа хэт хэлбийчихсэн байна. Үүнийг засаж залруулна. Гэхдээ тэнцвэртэй харилцаа тогтоох гэж байна гээд Хятадтай харилцаагаа хязгаарлаад, Оросоо дэмжээд явна гэсэн үг биш. Мэдээж Хятадтай тогтоосон харилцаагаа цаашид ч өргөжүүлнэ. Харин Оростой тогтоосон харилцааг тэр хэмжээнд хүртэл хурдтай авчрах зорилт тавина. Ерөнхийлөгч би бээр бизнесийн салбараас гаралтай хүн болохоор аливаа арилжаа наймаа нэг талдаа ашигтай биш, хоёр талдаа харилцан ашигтай байснаар илүү урт хугацаанд тогтвортой хөгжинэ<sup>2</sup> гэсэн байр суурьтай байлаа.

Ерөнхийлөгчийн анхаарсан хамгийн гол асуудал бол манай экспортын бүтээгдэхүүний асуудал юм. Хуучин Сибирийн зах зээл Монголынх байсан. Гэтэл өнөөдөр мах, ноос, ноосон бүтээгдэхүүн, арьс ширээ

1 Ерөнхийлөгч Х.Баттулга: Олон жил яриа хэлцлийн түвшинд өрнөсөн ажлыг бодит болгохын төлөө Ши Жиньпин дарга, В.В.Путин Ерөнхийлөгч нартай ойр дотно, идэвхтэй хамтран ажиллах эрмэлзэл дүүрэн байна, *sonin.mn* agency, 2018-06-09

2 Орос, Хятадтай сайн хөршийн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ, *president.mn/2017/08/24*

гаргаж чадахгүй байна. Үүнийг хоёр тал хэрхэн шийдэх гарцыг ОХУ-тай нухацтай ярилцахыг тэрээр зорьсон. Тэгснээрээ Монгол-Оросын харилцааг шинэ шатанд гаргана гэсэн зорилт тавьсан. Тэр нь ч Монгол, Оросын харилцааны хэтийн чиг хандлагыг тодорхойлно гэж үзсэн. Чухам хэр амжилтад хүрсэн эсэхийг монголчууд нийтгээрээ мэдэх тул энд дүгнэлт өгөхгүй. Гэхдээ хөдөлгөсөн, хоёр улсын хооронд Иж бүрэн стратегийн түншлэл тогтоолгож чадсан.

Технократ гадаад бодлогынх нь сонгодог жишээ нь АНУ-ын Конгрессын Төлөөлөгчдийн танхимд өргөн бариулсан “Гуравдагч хөршийн худалдааны хууль” байлаа. Хуулийн төслийг өргөн барьсантай холбогдуулан Ерөнхийлөгч дараах хэвлэлийн мэдээг түгээсэн. Үүнд АНУ-ын 117 дугаар Конгрессын Төлөөлөгчдийн танхимд хэлэлцүүлэхээр өргөн барьсан Гуравдагч хөршийн худалдааны хуулийн төслийг Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга бүрэн дэмжиж, Конгресс дахь Монголын бүлгийн дарга Дайна Тайтус, Дон Яанг нарт талархал илэрхийлж байна. Гуравдагч хөршийн худалдааны хуулийн төсөл нь Монгол Улсад үйлдвэрлэсэн оёмол, сүлжмэл бүтээгдэхүүнийг АНУ-ын зах зээлд татваргүй экспортлох боломжийг нээж

өгөх юм. Ерөнхийлөгч Х.Баттулга 2017 оны 12 дугаар сард АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трампд захидал бичиж, Монголд үйлдвэрлэсэн оёмол, сүлжмэл бүтээгдэхүүнийг АНУ-ын зах зээлд татваргүй экспортлох боломжийг олгох тал дээр дэмжлэг хүссэн билээ. Ийнхүү Гуравдагч хөршийн худалдааны хуулийн төслийг АНУ-ын 115 дугаар Конгресст 2018 онд, 116 дугаар Конгресст 2019 онд өргөн барьжээ. Гуравдагч хөршийн худалдааны хуулийн төсөл нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 7 дугаар сард АНУ-д хийсэн айлчлалын үеэр бүхий л түвшинд хэлэлцсэн онцлох сэдвүүдийн нэг байв. Хуулийн төсөл батлагдсанаар хоёр улсын худалдааны эргэлт, Монгол Улсын уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн салбарт аж үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлэх, эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт, иргэдийн тогтвортой орлогын баталгаа хангагдах зэрэг ач холбогдолтой. Тухайлбал оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний салбарт эхний ээлжинд 30 мянга гаруй ажлын байрыг шууд бий болгоно гэсэн тооцоо, судалгаа гарсан. Түүнчлэн уг хуулийн төсөл нь Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогыг бэхжүүлэх, Монгол Улс-АНУ-ын хооронд тогтоосон Стратегийн түншлэлийн харилцааг бататгахад онцгой ач холбогдолтой билээ<sup>3</sup> гэжээ.

3 Гуравдагч хөршийн худалдааны хуулийн төслийг АНУ-ын 117 дугаар Конгресст өргөн бариллаа, [president.mn/2021/04/23](http://president.mn/2021/04/23)

## Хоёр. Монгол ба Орос

ОХУ-тай харилцах бизнесийн чиглэлийг тав дахь Ерөнхийлөгч эрхэмлэсэн боловч санасан үр дүндээ тэр бүр хүрсэнгүй. Цар тахал ч нөлөөлөв. Бас Орос орон өөрөө олон талын хавчлага, санкц, геополитикийн амбицтаа хөтлөгдөөд Монголыг тэтгэх манатай байлаа.

Монгол-Оросын харилцааны салбаруудыг шинээр томъёолох, тэгснээрээ шинэ гарц боломжийг хайх талаар тав дахь Ерөнхийлөгч ихээхэн өөдрөг үзэл бодолтой нэгэн болохоо алхам тутамдаа илэрхийлж явсан. Үүнд буруу юм байхгүй.

Хамтын ажиллагааны гол салбар бол тэр үед, мөн одоогоор нэгдүгээрт батлан хамгаалах салбар байна. Монголын армийн зэвсэг техникийн 95 хувь нь Орост үйлдвэрлэгдсэн нь батлан хамгаалах салбарт хамтын ажиллагаа хэр байгааг илэрхийлнэ. Хоёрдугаар салбар нь хөдөө аж ахуйн салбар. СССР-ийн үед манай улс Зөвлөлтөд үйлдвэрлэсэн ХАА-н техник маш өргөн хэрэглэдэг байсан. Өнөөдөр ийм техник цөөрсөн учраас хөдөө аж ахуйн салбарт хамтын ажиллагаагаа бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай. Манай хоёр орон байгаль цаг уурын төстэй нөхцөлд оршдог. Бид монгол малын махыг Эрхүү мужид экспортлох талаар ярьж байна. Хамтын ажиллагааны гурав дахь салбар бол дэд бүтэц, тээврийн салбар юм. УБТЗ бол Орос-Монголын хамтарсан хөтөлбөрүүдийг өөрчилсний дараа үлдэж хоцорсон ганц төсөл нь. Оросын талтай 50:50 хувийн оролцоотой энэ төслийг өргөжүүлэхэд

онцгой анхаарах болно. Эрдэнэт үйлдвэрийн Оросын эзэмшлийн 49 хувь зарагдсан шиг ноцтой асуудал УБТЗ дээр бүү гараасай гэж хүсэж байна. Уул уурхайн хэд хэдэн лиценз эзэмшдэг “Монголросцвет” компани бий. Өнөөдөр асар их өртэй байгаа энэ компанийн үр ашгийг дээшлүүлэхийн тулд анхаарах хэрэгтэй. Хамтын ажиллагааны дөрөв дэх салбар бол аялал жуулчлал байх болов уу. Монгол бол үзэсгэлэнт сайхан байгалиараа давтагдашгүй орон. Оросын жуулчдыг Монголд ирэхийг нь нэмэгдүүлэх шаардлагатай. Аялал жуулчлал гэдэг бол чанартай үйлчилгээ, сайн удирдлага, зохицуулалт шаарддаг өвөрмөц салбар. Энэ жил бид шинэ нисэх буудлаа нээлээ. Энэ бол аялал жуулчлалын салбарт, ялангуяа Оросын жуулчдыг татахад том түлхэц болно. Оросын жуулчид өнөөдөр Монголд цөөн ирж байна. Үндсэндээ Сибирийн бүсээс л цөөн жуулчин автобусаар ирж амарч байна. Бид ОХУ-ын Буриадын аяллын товчоодтой Япон, БНСУ-ын жуулчдыг Буриад, Монгол Улс, Өвөр Монголд, өөрөөр хэлбэл “гурван Монгол”-оор аялуулдаг аялал жуулчлалын тойрог бий болгох талаар санал солилцсон. Хөшигтийн хөндийн нисэх буудал ашиглалтад орчихвол бид Москва, Санкт-Петербургээс ч жуулчид авах боломжтой хэмээн үзэж байна гэхчлэн ноён Х.Баттулга ярьсан, хэлсэн, санал бодлоо илэрхийлсэн.

“Эрдэнэт” үйлдвэрийг тухайн үеийн СССР-тэй хамтран байгуулж, Монголд зэс баяжуулах үйлдвэр барьж ажиллуулсан нь одоо хүртэл



Монголын эдийн засагт ашиг тусаа өгсөөр байна. Үүнтэй адилханаар Монголын говьд, Дорноговь аймгийн төв Сайншандад Эрдэнэттэй тэнцэхүйц аж ахуй байгуулахыг зорьж ажиллана. Үүнд ямар бодлого төлөвлөж байна вэ? Уул уурхайн бүтээгдэхүүнээ түүхийгээр нь экспортолдог биш, тодорхой хэмжээгээр боловсруулдаг арвин туршлагаа Эрдэнэтээр жишээлж тийм боловсруулах үйлдвэрээ Сайншандад барьж байгуулна гэсэн үг юм. Монгол нь гадаадын хөрөнгө оруулалт татах сонирхолтой бөгөөд үүнийг нэг тэргүүлэх чиглэл бол төмөр зам. Энэ салбарт “Улаанбаатар төмөр зам” (УБТЗ) хэмээх Монгол-Оросын 50:50 хувийн оролцоотой хувь нийлүүлсэн компани ажиллаж, чухал үүрэг гүйцэтгэж байна. Энэчлэн Монгол-Оросын уламжлалт хувь нийлүүлсэн компаниудыг тууштай дэмжиж ажиллана. Энэ бас л түүний үзэл бодол.

ОХУ-ын Алс Дорнодын “Восточный” боомтод Монголын нүүрсийг Зүүн Азид нийлүүлэх боломж байна. Монголоос Тавантолгойн сайн чанарын нүүрсийг төмөр замаар тэнд дамжуулж борлуулах боломж байна. Дэлхийн үнэ рүү ойртуулах боломж байна. Уул уурхайн бүтээгдэхүүнийг далайд гаргахын тулд дэд бүтэц хэрэгтэй. 5000 орчим км төмөр зам бүтээн байгуулах төсөл УИХ-аар 2010 онд оруулж батлуулсан. Үүний Тавантолгойгоос Сайншанд хүртэлх эхний хэсгийн 458 км төмөр замын ажлыг ирэх жилээс эхлүүлэхийг зорино. Энэ 5000 км

төмөр зам дээр хөндлөн буюу ОХУ, БНХАУ-ыг холбосон 3 транзит тээврийн төсөл хэрэгжүүлж болно. Үүн дээр дэд бүтэц гэсэн том төсөл буй. Энэ төслийг хоёр хөрштэйгээ хамтарч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна<sup>4</sup>.

Монгол-Оросын худалдааг тэрээр орвонгоор нь эргүүлэх бодолтой байсан. Зарим нэг үр дүн байна. Олон жил хөөцөлдсөний эцэст ОХУ-ын нутгаар дамжин өнгөрөх Монголын бараа, бүтээгдэхүүн Оросын боомтод очиход 25 хувийн тарифын хөнгөлөлт эдлүүлэх болсон нь том ололт юм. Чамлаж болохгүй. Үүнийг манай эдийн засаг-бизнесийнхэн ашиглах л хэрэгтэй.

Түүний ярьснаас эшлэе. 2017 оны эхний 7 сарын байдлаар Монгол Улс, ОХУ-ын худалдааны эргэлт 705.3 сая ам.долларт хүрсэн бөгөөд энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 46.8 хувь өссөн дүнтэй байна. Үүний дотор ОХУ-д гаргасан манай экспорт 33.4 сая ам.доллар буюу өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8.5 хувь, ОХУ-аас импортолсон бараа, бүтээгдэхүүн 671.9 сая ам.доллар буюу 49.5 хувиар тус тус өссөн байна. Ийнхүү өсөхөд хил орчмын бүс нутгийн худалдаа, эдийн засгийн харилцаа их үүрэг гүйцэтгэсэн. Хэдийгээр өссөн дүн харагдаж байгаа ч 4000 орчим км хуурай газраар хиллэдэг хоёр орны хувьд бас чамлалттай. Үүнийг өргөжүүлж, бүс нутаг хоорондын харилцааг дэмжиж ажиллах болно—Түүний амлалт.

ОХУ-ын хил орчмын Холбооны субъектуудтай харилцаж, хамтран

4 Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга: Тавантолгойн нүүрсийг төмөр замаар дамжуулж дэлхийн үнэ цэн рүү ойртуулах боломжийг харлаа, *president.mn/2017/09/06*

ажиллах нь хоёр орны хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал үүрэгтэй. Бүс нутгийн харилцаа хамтын ажиллагааг бид шинэ өндөрлөгт гаргах ёстой. Чөлөөт худалдааны бүс байгуулах, Байгаль нуурын талаар хамтран ажиллах, Эгийн гол дээр усан цахилгаан станц барих төсөл гэх мэт. Манай бүс нутгийн хооронд харилцан ойлголцох явдал дутмаг байгааг засаж залруулна. ОХУ-тай хийх худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, худалдаанд тулгарч буй тарифын болон тарифын бус саад тотгорыг арилгахын тулд ЕвроАзийн эдийн засгийн холбооны гишүүн орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах саналыг дэвшүүлсэн. Ойрын үед ЕвроАзийн эдийн засгийн холбооны гишүүн орнууд манай саналыг хүлээн авч нааштай шийдвэр гаргана гэдэгт найдаж байна<sup>5</sup> гэх мэтээр ярьж хэлж байв.

Монгол-Оросын хоорондын худалдаа-эдийн засгийн харилцаанд эргэлт гаргахын үндсийн үндэс нь улс төрийн итгэлцэл гэдэг дээр ноён Х.Баттулга бат зогсож байв. Үүндээ хүрэх бүх гарц хувилбарыг тэрээр эрэлхийлж ажилласан. ОХУ-тай стратегийн иж бүрэн түншлэлээ 2019 онд Ерөнхийлөгч В.Путины айлчлалын үеэр Найрсаг харилцаа,

иж бүрэн стратегийн түншлэлийн тухай гэрээгээр гарын үсэг зурж баталгаажууллаа. Монгол-Оросын харилцаанд Владивостокт зохиогддог Дорнын эдийн засгийн форум онцгой ач холбогдолтой хэмээн үзсэн нь 5 дахь Ерөнхийлөгчийн гадаад бодлогын нэг онцлог байв. Учир нь Дорнын эдийн засгийн форумын хүндэт талбарыг ашиглан Монгол Улс, ОХУ хоорондын худалдаа-эдийн засгийн харилцааг сэргээн өргөжүүлж, хөрөнгө оруулалт, худалдааг нэмэгдүүлнэ, Монгол, Оросын үйлдвэрлэгчид, экспортлогчид, бизнес эрхлэгчдийг холбож, тэдний үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүнийг сурталчилна, тэднийг холбох чухал гүүр бол Дорнын эдийн засгийн форум байх болно гэж үзсэн. Мөн гуравдагч хөршийн бодлогын тухайд энэ бодлогыг орхигдуулахгүй, эрчимжүүлэх ёстой бөгөөд энэ утгаараа Владивостокт Дорнын эдийн засгийн форумын үеэр Японы Ерөнхий сайд болон БНСУ-ын Ерөнхийлөгчтэй уулзаж байв. Монгол Улс аж үйлдвэрээ хөгжүүлэхэд тэргүүний технологи хэрэгтэй. Банк, санхүүгийн салбарт цаашдаа ч санхүүжилт хэрэгтэй. Үүнд гуравдагч хөршийн үүрэг оролцоо чухал гэдгээр хандсан. Тэрээр олон улсын энэ чухал форумд гурав дараалан оролцсон анхны Ерөнхийлөгчөөр тэмдэглэгдэнэ.

5 Мөн тэнд, *president.mn/2017/09/06*



## Гурав. Монгол ба Хятад

Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ноён Х.Баттулга 2017 онд сонгогдохдоо “Монгол ялна” гэсэн уриа дэвшүүлж, үндсэрхэг үзлийн хандлага гаргаж, тэр нь ч өмнөд хөршид гэнэтийн сюрприз болж, хоёр талын харилцаанд сүүдэрлэж эхэлсэн. Оросын тал баримтлагч, Орос руу түлхүү ажиллах хандлагатай, тиймээс Монгол-Хятадын харилцаа Х.Баттулгын өнгөн дээр урагшлахгүй юм байна гэх шахуу хардлага Хятадын талаас цухалзаж байв. Харин энэ хардлагыг ноён Х.Баттулга эерүүлж ажиллаж чадсан.

Тэрээр 2019, 2020 онд БНХАУ-д айлчилж, дээд өндөр түвшний айлчлалын давтамжийг илтгэж, “Гучин мянган хонь”-ны дипломат ажиллагаагаараа харилцаанд цоо шинэ эрүүл уур амьсгал оруулав.

Эрчимтэй хөгжиж байгаа бүс нутаг, хоёр хөршийнхөө дунд бид арал шиг үлдэж болохгүй хэмээн ноён Х.Баттулга үздэг, тэр хэрээрээ хоёр хөрштэй явуулах бодлогоо олж харахыг хичээсэн. 2019 онд БНХАУ-д төрийн айлчлал хийсний сацуу “Нэг бүс–Нэг зам” олон улсын хамтын ажиллагааны дээд хэмжээний II форумд оролцсон. Энэхүү айлчлал нь Монгол-Хятадын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой тэмдэглэх үед тохиосноороо бүр ч онцлог үйл явдал болжээ. Мөн “Нэг бүс–Нэг зам” санаачилгын бүтээн байгуулалтад Монголын талын илүү

гүн гүнзгий, бүх талын оролцоог нэмэгдүүлэх боломж, сэтгэл зүйн бэлтгэлийг Ерөнхийлөгч Х.Баттулга бодолцсон.

2019 оны айлчлалын үеэр БНХАУ-ын дарга Ши Жиньпин Монгол Улсын Ерөнхийлөгчид хандан хоёр орны иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг иж бүрэн утгаар шинэчилж, худалдааны эргэлтийг 2020 он гэхэд 10 тэрбум ам.долларт хүргэх, төмөр зам барих, боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлэх, бүс нутгийн энх тайван аюулгүй байдал гэх мэт олон чиглэлээр хамтран ажиллахдаа бэлэн байгаагаа илэрхийлсний хамт Монголын зүгээс дэвшүүлсэн ажил эрэгч саналуудыг хамтран хэрэгжүүлэхийн төлөө дэмжиж ажиллахаа мэдэгдсэн<sup>6</sup>. Ийм чухал мэдэгдлийг олзуурхан хүлээн авч, ажил хэрэг болгоход манай талаас шалтгаалсан бэрхшээл, мөн дэлхий нийтийг хамарсан цар тахал нөлөөлсөн нь мэдээж.

Технократ үзэлтэн Х.Баттулга Монгол-Хятадын харилцааны эмзэг талыг гярхай олж харан, өмнөд хөршийн асар их боломжийг монголчууд ашиглаж чадахгүй явж ирснийг байнга шүүмжлэн хэлдэг.

Түүний хэлснээс эшлэе:–Манай улс урд хөрштэйгөө 4700 орчим км хиллэдэг. Улаанбаатар хотоос зүүн хязгаар хүртэл 1000 орчим км. Харин баруун хязгаар хүртэл 1500 орчим км. Баруун, зүүн хязгаарын алслагдсан бүсэд байгаа иргэд

6 Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга БНХАУ-ын дарга Ши Жиньпintэй уулзлаа, [president.mn/5238/](http://president.mn/5238/)

Улаанбаатарт бараа таваар авчрах дэд бүтэц, тээврийн боломж байхгүй. Энэ тухайгаа Хятадын талд хэлсэн. Тус улсын Гадаад хэргийн сайд нь ч Увс аймагт очиж нөхцөл байдалтай нь танилцсан. Тиймээс үүнийг ойрын үед шийдэх байх. Үүнийг уулзахаараа л санаж ярьдаг биш, хоёр улсын Гадаад харилцааны сайд нар тогтмол уулзаж, ярилцаж, шийдвэрлэх чиглэлд түргэвчлүүлэхээр санал нэгдлээ. Хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, тодорхой хугацаагаар гаалийн татварын хөнгөлөлт үзүүлэх тухай л яриад байгаа гэсэн үг л дээ.

Энэ бол өмнөд хөршийн талаар явуулах түүний технократ, прагматик бодлогынх нь илэрхийлэл болох ганц жишээ.

Монгол, Орос, Хятад гурван улсын эдийн засгийн коридор байгуулах ажлыг манай тал санаачилж, 2018 онд өмнө гурван тал гарын үсэг зурсан боловч хэрэгжилт сайнгүй байна. Мэдээж энэ нь олон шалтгаантай. Ерөнхийлөгчөөс шалтгаалсан зүйл байхгүй. Эдийн засгийн коридор гэдэг бол “Бүс ба зам” төслийн нэг хэсэг, коридорын хүрээнд 32 төсөл хэрэгжүүлэх боломжтой хэмээн үзэж тодорхойлсон. Голдуу Монголын нутгаар дайраад Орос, Хятадыг холбосон дэд бүтцийн төслүүд. Эндээс алийг нь эхэлж хэрэгжүүлэх вэ гэдэг дээр шийдвэр гаргах цаг үе нь тулчихаад яваад л байна. Үүнд Ерөнхийлөгчөөс гадна УИХ, Засгийн газар, цаашлаад нийт монголчууд нэгдсэн санаа зорилго, бодлоготойгоор

ажиллах нь л үлдлээ.

Энд хэргээр тэмдэглэх нэг алхмыг нь дурдах нь зөв. Юу гэвэл 2019 онд БНХАУ-д цар тахал дэгдсэнээс хойш айлчилсан гадаадын орны анхны төрийн тэргүүн нь болж, 30 мянган хонь хандивлах санал тавьсан явдал болно. Энэ бол БНХАУ-д хийсэн түүний албан ёсны айлчлал. Тэрбээр БНХАУ-ын дарга Ши Жиньпинтэй уулзахдаа БНХАУ “Ковид-19”-тэй тэмцэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлж, Монголын ард түмнээс 30 мянган хонь хандивлажээ. Хандив өргөх үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч “Цар тахлын дэгдэлтийн хугацаанд Монгол Улсын Засгийн газар БНХАУ-д туслах “Мөнхийн хөршдөө сэтгэлийн дэмжлэг” нэртэй хандивын аян өрнүүлж буйгаас гадна Монголын ард түмэн, аж ахуйн нэгжүүд сайн дурын санаачилгаар сэтгэлийн хандив цуглуулж, БНХАУ-ын талд хандивласан. Мөн энэ удаагийн айлчлалын хүрээнд Монголын ард түмнээс 30 мянган толгой хонь хандивлаж байгаа нь мөнгөн дүнгээс илүүтэй хоёр улсын гүн бат харилцааг хэмжих юм” гээд БНХАУ-ын ард түмэнд сайн сайхныг хүсчээ. Энэ үйл явдлыг Хятадын хэвлэл, телевизүүд “Үнэхээр гайхалтай үйл явдал болж байна” хэмээн тэр өдрүүдэд онцолж, хожим энэ талаар дуу, уран бүтээл төрж, хятад хүмүүсийн зүрх тархинд санаандгүй тохиолдлоор хүргэсэн ардын дипломатын, “зөөлөн хүч”-ний томхон бодлого болж мөнхөрчээ.

7 Гучин мянган хонь Монгол-Хятадын харилцаанд шинэ үүд хаалгыг нээж байна, *montsame.mn/241347*

## Дөрөв. Гурвалсан харилцаа

Манай аль ч Ерөнхийлөгчийн өнгөн дээр хоёр хөрш болох ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцааг бүх салбарт гүнзгийрүүлэн хөгжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл байж ирсэн, байгаа. Энэ бодлого амжилттай хэрэгжиж, хөршүүдтэй хөгжүүлж буй харилцаа, хамтын ажиллагаа иж бүрэн стратегийн түншлэлийн түвшинд хүрсэн. Үүнд халаагаа өгөх гэж буй тав дахь Ерөнхийлөгчийн хувь нэмэр гэж бий.

Хэдийгээр өнөөдөр ард иргэддээ дуурсагдахгүй байгаа боловч ноён Ц.Элбэгдорж өөрөө 2014 оны хавар санаачилж, намар хэрэгжүүлж эхлүүлсэн гурван улсын Төрийн тэргүүн нарын уулзалтын механизмыг энд дурдахгүй өнгөрч болохгүй. Энэ бол санаачилга нь Монголоос байсан боловч гурван талаас гаргасан хүч чармайлтын бодит үр дүн байлаа. Гурван талын хамтын ажиллагааны механизмыг нэгэнтээ төлөвшүүлж бүрдүүлж чаджээ. Гурвалсан дээд хэмжээний уулзалтууд ямагт ШХАБ-ын Төрийн тэргүүн нарын хуралдааны үеэр тохиож хэвшлээ. 2014-2019 онд 5 удаа уулзжээ. 2020 онд цар тахлын бодит хүчин зүйлээс болж энэ уулзалт хойшилж, ШХАБ-ын дээд хэмжээний уулзалт цахимаар явагдсан.

Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгч нь ШХАБ-ын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын өргөтгөсөн хуралдаанд оролцохоор 2018 онд Хятадын Циндао хотыг зорихдоо Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Төрийн тэргүүн нарын 4 дэх удаагийн уулзалт, 2019 онд Киргизстаны нийслэл Бишкек хотноо 5 дахь удаагийн уулзалтад оролцсон. Энэхүү чухал гурван талт механизмыг хэр чинээндээ ашиглахыг ч зорьсон. 2018 оны уулзалт түүний анхны уулзалт байсны хувьд анхаарал татсан. Түүнд оролцохдоо тэрээр бодлого, байр сууриа дараах байдлаар нэн тодорхой томъёолсноос<sup>8</sup> дор эшлэе.

Нэгдүгээрт, Эдийн засгийн коридорын хөтөлбөрийн хэрэгжилтийг эхлүүлэх. Гурван талын үзэглэсэн<sup>9</sup> “Эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтыг урагшлуулах хамтарсан механизм байгуулах тухай Харилцан ойлголцлын санамж бичиг”-т ойрын хугацаанд гарын үсэг зурах шаардлагатай. Хамтарсан механизм бий болж байж гурван талын хооронд уулзалт, мэдээлэл солилцоо идэвхжиж, хэрэгжих явцыг түргэтгэх юм. Нэн тэргүүнд хэрэгжүүлэхээр тохиролцсон төслүүд, тухайлбал Төмөр замын төв коридорыг шинэчлэн хөгжүүлэх, хос зам барих, цахилгаанжуулах

8 Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын дөрөв дэх удаагийн дээд хэмжээний уулзалтад оролцож үг хэллээ, [president.mn/4238/](http://president.mn/4238/)

9 Ерөнхийлөгчийн үгийг бэлтгэж өгөхдөө буруу нэр томъёо сонгосон байна. Үзэглэх гэдэг нь хүчин төгөлдөр бус, баримт бичгийн эх дээр тохиролцлоо л гэсний баталгаа, хуудас болгон дээр ажлын хэсгийн ахлагч нар нэрийн эхний үсгээ зурсан, нэг ёсондоо төсөл-баримт бичиг. Үүнийгээ албажуулаад дараа нь албан ёсоор гарын үсгээ зурдаг. Үзэглэх, гарын үсэг зурах гэдгийг хольж хутгаж байгаа нь буруу юм – Зохиогч

төсөл, Азийн автозамын сүлжээний АН-3 чиглэлийг дамжин өнгөрөх тээвэрлэлтэд идэвхтэй ашиглах, тус чиглэлд хурдны авто зам барих төслийг ажил хэрэг болгохын төлөө илүү их идэвх чармайлт гаргахыг уриалж байна. Тухайлбал, Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлд хурдны авто зам барихад гурван улсын Засгийн газрын оролцоог шууд, тэгш хэлбэрээр хангаж, төслийн санхүүжилтийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж бүтээн байгуулалтыг ойрын үед эхлүүлэх саналыг миний бие дэвшүүлж байна. Гурван талын оролцооны хувь, санхүүжилтийн хэлбэр зэргийг гурван улсын Зам, тээврийн яамд хэлэлцэн тохиролцоо боломжтой. “Азийн авто замын сүлжээгээр олон улсын авто замын тээвэрлэлт гүйцэтгэх тухай гурван улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг гурван тал соёрхон баталж, удахгүй хүчин төгөлдөр болж байгаа нь уг замыг ойрын хугацаанд барих таатай нөхцөл бүрдүүлнэ хэмээн итгэж байна. Цаашид Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт тусгагдсан төслүүдийн нарийвчилсан судалгаа хийх, эдийн засгийн үндэслэлийг сайтар боловсруулах үүднээс Хөрөнгө оруулалтын зураг төслийн хамтарсан төвийг байгуулахыг яаравчлах нь зүйтэй гэж үздэгээ дашрамд илэрхийлье.

Хоёрдугаарт, гурван талт хамтын ажиллагааны бусад чиглэл, механизмын тухайд. Цаашид гурван улсын Төрийн тэргүүн нарын уулзалтын бэлтгэлийг хангах хүрээнд гурван улсын Тээврийн сайд нарын уулзалтыг зохион байгуулж,

дэд бүтцийн төслүүдийг бодитоор хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой тус механизмыг тогтмолжуулах саналтай байна. Аялал жуулчлал нь гурван талын хамтын ажиллагааг өргөжүүлэх өргөн боломжтой салбар бөгөөд Цайны замыг сэргээх тал дээр гурван тал анхаарч байгаад баяртай байна. 2019 онд болох “Silk Way” авто замын уралдааныг Монголын нутгаар дайруулан өнгөрүүлэх асуудалд хоёр хөршийн тэргүүн анхаарал хандуулж өгнө үү гэж хүсье. Монголын талаас удаа дараа тавьж буй Орос, Хятадыг холбох газрын тос, байгалийн хийн хоолойг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх саналыг орос, хятадын талууд хүлээн авч, нааштай хандана гэж найдаж байна гэжээ.

“Нэг бүс–Нэг зам”-ын бүтээн байгуулалт гурвалсан хамтын ажиллагааны нэг гол тулгуур байх болно гэдэгт Монголын тал итгэдэг. Хоёр хөршийн санал болгосноор, “Нэг бүс–Нэг зам”-ын бүтээн байгуулалтын хүрээнд Оросын хөгжлийн стратеги, ялангуяа Европ, Азийг сундалсан их замын бүтээн байгуулалт, Монголын “Хөгжлийн зам” санаачилгыг энэ гол шугам дээр харилцан холбож, хөрш орны газар зүйн давуу талыг оновчтой ашиглах, тэгснээрээ үе шаттайгаар хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлнэ. Хаяа нийлсэн газар зүйн хүчин зүйл нь тэр чигээрээ давуу тал болно. Эдийн засгийн даяаршил, бүс нутгийн интегралчлал гүнзгийрч буй өнөөгийн цаг үед гурван тал хамтран харилцан ашигтай, хамтдаа ашиг хүртэх, хөгжлөө нэгтгэх үр өгөөжтэй замыг сонгож, хөрш гурван улсын гурвалсан

хамтын ажиллагааны үлгэр жишээ болох ёстой хэмээн Хятадын удирдагч өөрөө ярьсан байдаг.

Хоёр хөрштэй тогтоосон манай эдийн засаг-худалдааны харилцаа нөгөө хоёр хөршийн өвөр хоорондын худалдаа-бизнесийн харилцаанаас ихээхэн хамааралтай, өөрөөр хэлбэл тэр хоёр улс манайхыг алгасан худалдаа арилжаа хийж байсан ч Монголд ямар нэг үлдэцтэй байх ёстой гэж үзсэн Төрийн тэргүүн бол ноён Х.Баттулга өөрөө юм. Түүний ярьснаас:– Хятадын цэвэр усны компани Оросын Дорноос цэвэр ус савлаад, Хятад руугаа экспортолж

байна. Өөрөөр хэлбэл, бид ч гэсэн судалж байгаад эндээс яаж ашигтайг нь авах вэ гэдгийг төрийн бодлогын түвшинд хэрэгжүүлж, хувийн компаниуд ч идэвхтэй ажиллах хэрэгтэй<sup>10</sup>.

Эдүгээ Монгол, Орос, Хятадын хувьд улс төрийн итгэлцэл, иж бүрэн стратегийн түншлэл эрх зүйн хувьд бүрэн баталгаажсан. Ийм бат бөх суурин дээр хамтын ажиллагааны гол гол төслийг ахиулах, тэгснээрээ бүх талын хамтын ажиллагаа хөгжүүлж, гурван улсын эдийн засгийн хонгилын хөтөлбөрөө хэрэгжүүлэх л үлдлээ.

### Тав. Гуравдагч хөршүүдтэй

Тав дахь Ерөнхийлөгч Х.Баттулга нь хоёр хөршдөө баригдаад гурван талын харилцаандаа түүртээд өрнөдийн ардчилсан түншүүдээ орхичихсон мэт сэтгэгдэл монголчуудын дунд мэр сэр цухалздаг. “Элбэгдоржийн гадаад бодлогын үнэт өвийг орхигдуулсан” гэх шүүмжлэл ч АН-ын дарга нарын зүгээс ганц нэг удаа хэлэгдсэн.

Анхандаа ийм сэтгэгдэл төрүүлсэн байхыг үгүйсгэх аргагүй. 2017-2018 онд Орос руу түлхүү анхаарч, ШХАБ-д жинхлэх хэрэгтэй хэмээн ярьж, тэр нь Монголын нийгэмд сенсаац дэгдээснийг гуравдагч хөршөө үл тоолоо гэж үзэхэд арай ч хөнгөднө, хэтрүүлэг болно хэмээн би тухайн үед нь тэмдэглэж, харин ч сөргүүлж бичиж байсансан.

Газар нутгийн хувьд Азид байрладаг, том утгаараа глобал

геополитикийн өнцгөөс авч үзвэл Монгол нь Ази-Номхон далайн бүс нутгийн улс юм. Манай улсын нэг онцлог бол Европын улсуудтай Оросоор хиллэдэг, Азийн орнуудтай Хятадаар хиллэдэг. НҮБ-ын гишүүн бараг бүх улс оронтой дипломат харилцаатай. Гадаад харилцааны жин нөлөөг нь авч үзвэл Монгол нь дэлхийн ба бүс нутгийн улс төрийн бодлого тодорхойлоход жолдох боловч давуу тал олонтой. Дипломат харилцаа тогтоосон улс орны зөвхөн тоон үзүүлэлтээс гадна дэлхийн хоёр том гүрэн Орос, Хятадын дунд оршдог, тэр хэрээрээ олон улсын анхаарлын төвд байх магадлал өндөр. Тоталитар, хагас тоталитар дэглэмтэй хоёр гүрний дунд ардчиллын тугч болж яваа нь экзотик үзэгдэл мөнөөсөө мөн. Түүндээ эрхбиш үнэнч явна. Хоёр хөрштэй эн тэнцүү

10 Х.Баттулга: Хүрэн нүүрсийг эрчим хүч болгож, экспортлох саналаа илэрхийллээ, *eagle.mn/* 2018-09-14

иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаатай. АНУ, Япон, Энэтхэгтэй стратегийн түншлэлийн харилцаатай. Газар зүйн байрлал ба дээрх давуу тал, онцлогийг ашиглаж гадаад харилцаагаа өргөжүүлэхэд тус нэмэр хүргэх нь ноён Х.Баттулгын бодлогын нэг онцлог байв.

Тэрээр Зүүн хойд Азийн бүс нутгийн эдийн засгийн чухал уулзалтад (Дорнын эдийн засгийн форум) Монгол Улс төрийн тэргүүний түвшинд гурван удаа угсраагаар оролцсон рекордыг тогтоогоод байна. Засгийн газраас хэрэгжүүлэхээр төлөвлөж буй эдийн засгийн томхон төслүүдээ тэнд танилцуулж, гарц боломж бүрийг ашиглахыг зорьсон. Хоёр талын айлчлал хийж, зардал чирэгдэл, хөл болохгүйгээр иймэрхүү чуулга уулзалтын индрийг ашиглаж болно гэдгийг ноён Х.Баттулга харуулж чадсан. 2017, 2018 онд Дорнын эдийн засгийн форумын үед Японы Ерөнхий сайдыг хүлээн авч уулзахдаа, хоёр орны хамтын ажиллагааг улам бүр эрчимжүүлэх хүсэлтэй байгаагаа илэрхийлж, бүр тодорхой салбарыг хөндөж ярьж байв<sup>11</sup>. Японы дэмжлэгээр ноос, ноолууран бүтээгдэхүүний “Говь” үйлдвэр, Дархан төмөрлөгийн үйлдвэр, Хөшигтийн хөндийн шинэ нисэх буудал, Нарны гүүр гэх мэт олон том бүтээн байгуулалт хийгдсэн нь монголчуудад ихээхэн үр өгөөжтэй хөрөнгө оруулалт байсныг онцлон тэмдэглэсэн. Монголд аж үйлдвэр хөгжүүлж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, эдийн засгаа

тэлэх бодлогын хүрээнд дэд бүтэц болоод боловсруулах үйлдвэрийн салбарт Японтой ойр дотно хамтран ажиллах сонирхлоо илэрхийлсэн. Мөн ОХУ, Япон улстай хамтарсан аж ахуйн нэгж байгуулж, Тавантолгойн сайн чанарын коксжих нүүрсийг дэлхийн зах зээлд гаргах зорилгоор Алс Дорнодын бүс нутагт боомт байгуулан ажиллах санал тавьсан. Япон Улсын Ерөнхий сайд Ш.Абэ хариуд нь батлан хамгаалах салбарт хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, НҮБ болон Зүүн хойд Азийн бүс нутаг түүний дотор Солонгосын хойгийн асуудлыг шийдвэрлэхэд нягт хамтран ажиллах санал тавьсан. Япон улсын Засгийн газраас Монгол Улсад 850 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэснийг мэдэгдэж Монгол Улс далайд гарцтай болох, эдийн засгийн харилцаагаа тэнцвэржүүлж, тэлэх бодлого баримталж байгааг дэмжиж байгаагаа илэрхийлж байсныг эргэж санах нь зөв биз ээ.

2017 онд Монгол Улс-БНСУ-ын хоёр Ерөнхийлөгчийн уулзалт дээр ноён Мүн Жэ Ин хэлэхдээ: Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга нь бизнесийн салбараас төрсөн улс төрч, УИХ-ын гишүүн, хоёр удаа сайдаар ажиллаж байсан туршлагатай хүний хувьд ажлаа амжилттай хийнэ гэж итгэж байна. Ялангуяа авлигатай тэмцэх, улс орноо хөгжүүлэх хүсэлтэй хүний хувьд энэ талаараа бид хоёр адилхан гэж бодож байна гэжээ. Мөн тэрээр “Монгол Улс, БНСУ-ын хооронд хэл, түүх, газар зүйн хувьд

11 Япон улсын Ерөнхий сайд Шинзо Абэ Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхав, [president.mn/5212/](http://president.mn/5212/)



ижил төстэй зүйлс байдаг учраас ах дүүс гэж боддог. Монголоос олон хүн БНСУ-д ажиллаж, амьдарч Солонгосын эдийн засагт хувь нэмрээ оруулж байгаа. Бидний уулзалт хоёр орны харилцааг улам хөгжүүлэх сайхан уулзалт болоосой гэж хүсэж байна” гэсэн бол Ерөнхийлөгч Х.Баттулга БНСУ-ыг асар богино хугацаанд үсрэнгүй хөгжилд хүргэсэн удирдагчдын түүхийг сонирхон судалсан талаараа дурдаж, тус улсын Ерөнхийлөгчтэй анх удаа уулзаж байгаа хэдий ч цаашид нягт хамтран ажиллаж, хоёр орны найрсаг хамтын ажиллагааг илүү амжилттай хөгжүүлж чадна гэж найдаж байгаагаа илэрхийлсэн. Тэрээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн хувиар БНСУ-д ажиллаж амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн талаар баримтлах бодлогодоо уян хатан хандахыг хүсээд улс орон маань хөгжиж монголчууд тус улсад ажиллах гэж биш жуулчилж очдог болох цаг ойрхон байгаа гэж бодлогоо хэлжээ. Мөн Монгол Улсын иргэд БНСУ-д зорчих боломжийг илүү нээлттэй болгож, визгүйн хэлэлцээрт анхаарал хандуулахыг хүсэж байв<sup>12</sup>.

Дээр жишээ болгож хоёр уулзалтаас эшлэв. Энэчлэн Дорнын эдийн засгийн форумд асуудал дэвшүүлж хөөцөлдсөн сэдэв мундахгүй. Хөдөө аж ахуй, аялал жуулчлал, газрын баялгаа нэмүү өртөг шингээн экспортлох, бүс нутаг дахь оролцоогоо нэмэгдүүлэх, тодорхой ярьвал манай том боломж гэгддэг

хүрэн нүүрсийг газар дээр нь эрчим хүч болгож, экспортлох саналаа ч бүс нутгийнхаа орнуудад хүргэж байв. Энэ чиглэлээр ОХУ, БНХАУ-тай хамтран ажиллахаас гадна эдгээрийг нэгтгэж, Зүүн Азийн эрчим хүчний хамгийн том хэрэглэгч болох Япон, Солонгост нийлүүлэх хувилбар дэвшүүлж ярилцжээ. Зүүн хойд Азийн эрчим хүчний супер сүлжээний нийлүүлэгч болох манай саналын хариуд БНСУ нааштайгаар хүлээж авч буйгаа илэрхийлсэн.

Коксжсон нүүрсний гурван том хэрэглэгч манай бүс нутагт байгаа нь БНХАУ, БНСУ, Япон улс. Харин хажууд нь байгаа бидэнд нүүрс нь байна. Гашуунсухайтаар гарч буй нүүрс зөвхөн нэг худалдан авагчтай учраас бид дэлхийн зах зээлийн үнээр өгч чаддаггүй. БНСУ, Японд эцсийн хэрэглэгчид очиж буй нэг киловатт эрчим хүч 20 цент. Харин манай улсын нийлүүлэх эрчим хүч хамгийн ихдээ 15, цаашилбал 10 цент байх боломжтой. Учир нь Хятадын эрчим хүчний компани 1000-1500 орчим км-т нийлүүлэхэд алдагдалгүй байх шугамын технологи нээсэн. Өөрөөр хэлбэл, 1000 км-т 1.2 киловаттын алдагдалтай байх технологи юм<sup>13</sup> хэмээн 5 дахь Ерөнхийлөгч өөрөө ярьсан байдаг.

Энд зориуд тэмдэглэхэд, гуравдагч хөрштэй тогтоосон харилцааны түүхэнд Монгол-Америк, Монгол-Япон, Монгол-Энэтхэгийн стратегийн түншлэлийн харилцаа

12 Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, БНСУ-ын Ерөнхийлөгч Мүн Жэ Ин нар уулзав, *president.mn/1839/*

13 Х.Баттулга: Хүрэн нүүрсийг эрчим хүч болгож, экспортлох саналаа илэрхийллээ, *eagle.mn/ 2018-09-14*

ноён Х.Баттулгын өнгөн дээр ил тодоор бичигдэн үлдэж байна. Монгол Улсын гадаад бодлогын нэн чухал тулгуур болох өрнө, дорнын тэргүүлэх чиглэлийн улсуудтай найрсаг харилцаа хөгжүүлж, тэдгээрийн эдийн засгийн болон бусад бодит сонирхлыг Монголд бий болгох зорилт 2018-2019 онд амжилттай хэрэгжлээ. АНУ-тай стратегийн түншлэл тогтоохоор ажилласан, Өргөтгөсөн иж бүрэн түншлэлийн харилцааг АНУ-тай 2018 онд тунхагласнаа жил хүрэлгүйгээр 2019 оны зун Стратегийн түншлэлээ зарлаж чадлаа. Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн АНУ-д 2018 оны намар хийсэн албан ёсны айлчлалын тухай Хамтарсан мэдэгдэлд АНУ-ыг “чухал гуравдагч хөрш”, “дотнын анд”, “чухал түнш орон”<sup>14</sup> хэмээн бүр нэрлэсэн байгаа нь улс төрийн гүн агуулга бүхий дүгнэлт гэж ойлговол зохилтой.

АНУ-тай харилцааны түвшин ямар хэмжээнд хүрснийг илтгэх эшлэл авъя. Ноён Х.Баттулгатай хамтран ажилласан, тухайн үеийн Гадаад харилцааны сайд ярьжээ. ГХЯ-ны өнгөрсөн 4 жилийн үр дүнтэй ажлуудын эхэнд Монгол Улс АНУ-тай стратегийн харилцаатай болж чадсаныг ийнхүү илэрхийлжээ:– Харилцааны томъёоллууд 10-аас доошгүй жилд нэг удаа өөрчлөгддөг. Ер нь тийм ч амар өөрчлөгдөөд байдаггүй. Харин бид 2018 онд АНУ-тай иж бүрэн түншлэлээс өргөтгөсөн иж бүрэн түншлэлийн харилцаа руу шилжиж, дараа жил нь стратегийн

түншлэлийн харилцаанд шилжсэн. Энэ бол байж болох хамгийн дээд түвшний харилцаанд хүрч байгаа нь тэр. Монгол Улс НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын 5 гишүүн орны гуравтай нь стратегийн түншлэлийн харилцаатай болсон. Өөрөөр хэлбэл, манай стратегийн түншлэгч орнуудын тоонд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн олонхи орж ирж байна гэсэн үг. Энэ бүгд манай улсын гадаад бодлого, гадаад харилцаа, аюулгүй байдалд тун чухал нөлөөтэй. Монгол Улсын бүс нутагтаа эзлэх жин байр суурь бэхжиж, дараа дараагийн хамтын ажиллагааны төслүүдийг хэрэгжүүлэхэд маш том түлхэц болдог. Бид АНУ-тай Мянганы сорилтын сангийн 350 сая ам.долларын буцалтгүй тусламжийн төсөл хэрэгжүүлж байна. Манай ноос, ноолууран бүтээгдэхүүнийг дэмжсэн гуравдагч хөршийн хууль Конгресст өргөн баригдсан. АНУ-ийн Конгресст хууль өргөн баригдана гэдэг нь өөрөө маш нарийн процесс, тийм амар ажил биш. Өргөн баригдаад, хэлэлцэгдээд эхэлнэ гэдэг маш том алхам болж байна Тэнд олон улстөрч дэмжиж байгааг илэрхийлж байгаа хэрэг. Энэ хуулийг өргөн барихад Конгрессын гишүүд нам үл харгалзан дэмжсэн. Бүхий л зүйл дээр хоёр тал болж, ширүүн өрсөлддөг тэднийг энэ хуулийг дуу нэгтэй дэмжиж байгааг гайхаж байгаагаа америкчууд хэлж байсан шүү. Гуравдагч хөршийн хууль батлагдвал манай ноос, ноолуурын зах зээл тэлж, экспортод эерэг нөлөө

14 Өргөтгөсөн иж бүрэн түншлэлийн тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын Хамтарсан мэдэгдэл, *mfa.gov.mn*, 2018-09-21

үзүүлнэ<sup>15</sup> гэжээ.

АНУ “чухал гуравдагч хөрш” гэдгээ нотлосон алхам бол тус улсын Конгрессын Төлөөлөгчдийн танхим Монгол-Америкийн стратегийн түншлэлийг бэхжүүлэх тухай тогтоол<sup>16</sup> 2020 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа батласан явдал байв. Тогтоолд Монголын ардчилал, өөрчлөлт шинэчлэлийн ололтууд, Монгол, Америкийн харилцаа, хамтын ажиллагааны амжилтууд, тухайлбал хоёр улс 2019 онд стратегийн түншлэлийн харилцаа тогтоосон, хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх Замын зураглалыг тохиролцсон, МСК-ын Хоёрдугаар компакт гэрээ, Ил тод байдлын хэлэлцээр, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа зэргийг онцолжээ.

Японтой XXI зууны “Иж бүрэн түншлэл”-ийн харилцааг урагшлуулах чиглэлээр ажилласаар, анхлан 2010 онд үндсэн зорилгоосоо давж Стратегийн түншлэлд хүрсэн бол 2018 онд уг түншлэлийг бүхий л салбарт бэхжүүлэх зориг эрмэлзлээ нотолсон “Монгол Улс, Япон Улсын Стратегийн түншлэлийг улам бүр бэхжүүлэх тухай хамтарсан мэдэгдэл”<sup>17</sup> гаргав. Монгол Улсын “гуравдагч хөрш” улсууд дотроос нэн тэргүүнд “Стратегийн түншлэл”-ийн харилцаа тогтоосон чухал түнш Японтой харилцаа, хамтын ажиллагаагаа улам бүр гүнзгийрүүлэн хөгжүүлэх нь ноён Х.Баттулгын төр

толгойлсон 4 жилийн гадаад бодлогын нэг онцлог байв. “Чөлөөт, нээлттэй Энэтхэг, Номхон далай”-г цогцлоохоор ажиллаж байгаа Японы үйл ажиллагааг Монголын тал дэмжсэнээ илэрхийлэв. Монгол, Японы улс төрийн дээд түвшний айлчлал, яриа хэлэлцээний давтамжийг хадгалах нь бүү хэл улам ойртуулах чиглэлээр ажиллаж, Ерөнхийлөгч Х.Баттулга, Ерөнхий сайд Ш.Абэ нар дээд хэмжээнд тогтмол уулзаж байв. Ерөнхий сайд ч хоёр дараалан Японд айлчилж. Японы Гадаад хэргийн сайд мөн хоёр дараалан Монголд айлчилжээ.

Гуравдагч хөршийн бодлогын амжилттай яваа нэг үзүүлэлт бол Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс, Япон Улсын гурван талт уулзалтын<sup>18</sup> механизм юм. Гурван талт эл уулзалт нь бүс нутгийн болон олон талт хамтын ажиллагаа, харилцан ашигтай эдийн засгийн хөгжлийн асуудлаар санал солилцох чухал механизм болж байдаг бөгөөд 2020 оны нэгдүгээр сард Вашингтон хотноо сүүлчийн уулзалт тохиосон. Монгол Улс, АНУ, Японы Хамтарсан мэдэгдэлд “Монгол Улс, АНУ, Япон Улс нь бүс нутгийн хөгжил, түүний дотор Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн хэтийн төлөвийн талаар тус тусын саналаа танилцуулж, бүрэн эрхтэй, тусгаар тогтносон, ардчилсан орнууд бүхий хөгжин цэцэглэсэн, энх тайвныг эрхэмлэсэн бүс нутгийг цогцлоохын төлөө хамтран

15 Д.Цогтбаатар: Том эрх ашгийг сөрснөөрөө би олон дайсантай болж байгаа, [ikon.mn/](http://ikon.mn/)

16 АНУ-ын Конгресс Монгол, Америкийн харилцааг бэхжүүлэх тухай тогтоол батлав, [mfa.gov.mn/](http://mfa.gov.mn/) 2020.12.08

17 Монгол, Японы Стратегийн түншлэлийг бэхжүүлэх мэдэгдэл гаргалаа, [news.mn/r/2059581/](http://news.mn/r/2059581/); Монгол Улс, Япон Улсын стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг танилцуулав, [mfa.gov.mn/](http://mfa.gov.mn/) 2018.12.14

18 Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс, Япон Улсын хамтарсан мэдэгдэл, [mfa.gov.mn/](http://mfa.gov.mn/)

ажиллах талаар санал солилцов. АНУ нь 2019 онд Япон Улсын адил Монгол Улсын стратегийн түнш болсныг гурван тал талархан тэмдэглэж, стратегийн түншлэлийг улам бүр бэхжүүлэх эрмэлзлэлээ илэрхийлэв<sup>19</sup> гэсэн нь Монгол нь гуравдагч хөршийн бодлогоосоо ухрахгүй, гуравдагч хөрш гэх орнууд дотроо АНУ, Японыг ямагт чухалчилна гэсний тов тодорхой илэрхийлэл болжээ.

Манай улсын гуравдагч хөрш орнуудаас Энэтхэгийг энд онцлох нь зөв байх. Тав дахь Ерөнхийлөгч тус улсад 2019 онд айлчилж “Стратегийн түншлэлийг улам бэхжүүлэх тухай”<sup>20</sup> хамтарсан мэдэгдэл гаргажээ. Уг айлчлалаар хоёр орон улс төр, худалдаа, эдийн засаг, уул уурхай, хүнд үйлдвэр, зам тээвэр, хөдөө аж ахуй, боловсрол, соёл, мэдээллийн технологийн зэрэг өргөн хүрээтэй хамтын ажиллагаа өргөжүүлэх асуудлаар дэлгэрэнгүй

ярилцжээ. Энэтхэгийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжүүлж буй Газрын тос боловсруулах Монголын анхны үйлдвэрийн төслийг хэрэгжүүлж дуусгах, коксжих нүүрс зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн Энэтхэг рүү экспортлох ажлыг эхлүүлэх асуудлаар одоо ажиллаж байна. Дэлхий нийтийг хамарсан “Ковид-19” цар тахлын үеэр бүс нутгийн улс орнууд нягт хамтран ажиллаж чаддагийн жишээг Монгол, Энэтхэг хоёр харуулж чадсаныг энд зориуд тэмдэглэе.

Ер нь 2019 он ноён Х.Баттулгын гадаад бодлогын оргил жил байсныг энд тэмдэглэх хэрэгтэй. Иж бүрэн стратегийн ба стратегийн түншлэл бүхий 5 гүрэнтэй (ОХУ, БНХАУ, АНУ, Япон, Энэтхэг) тэнцвэрийг барьсан, аль алинтай нь харилцааны далайцыг нэмэгдүүлсэн айлчлалуудыг амжилттай зохион байгуулжээ.

### Зургаа. ШХАБ

Ноён Х.Баттулгын явуулсан гадаад бодлого дотор ШХАБ хүндтэй байрыг эзлэх нь мэдээж. Хүндтэй бөгөөд сонирхолтой, зарим талаар эгзэгтэй ч гэж хэлж болох болов уу. Учир нь бизнесийн салбарын төлөөлөл болж Төрийн тэргүүнээр ирсэн, аливаа гадаад харилцааг эх орны хөгжилтэй уяхыг хүсдэг, ядарсан жирийн ард түмэн ба баялаг бүтээгч цөөнхдөө гадаад бодлогын давуу талыг ашиглуулах гэдэг тэр байр сууринаасаа ШХАБ-ыг олж харахыг хичээж байв. Тэр хичээл зүтгэл нь хэрэгжсэнгүй.

Гэхдээ өөрөөс нь болсон юм биш.

Тэрээр эхний нэг жилдээ дотоод асуудалдаа түүртээд ШХАБ-аар оролдох завгүй байсан биз. Бас түүнд зөвлөдөг, мэдээлэл хүргэдэг албад нь, зөвлөхүүд нь буруу мэдээлэл өгч, буруу тийш нь залуурдахыг оролдсон байж болно. Гэхдээ энэ бол хардлага төдий. Ямар ч атугай Монголыг тойруулсан ШХАБ-ын эдийн засгийн лут интеграцын тухай төсөөллийг түүнд өгсөн байв. Явж явж ажиглагч бид л ШХАБ-ын интеграцаас хоцорчихлоо, биднийг тойруулаад

19 [mn.usembassy.gov/mn/joint-statement-mongolia-japan-u-s-trilateral-meeting-mn/](https://mn.usembassy.gov/mn/joint-statement-mongolia-japan-u-s-trilateral-meeting-mn/)

20 Монгол-Энэтхэгийн стратегийн түншлэлийг шинэ агуулгаар баяжуулав, [montsame.mn/2019-09-26](https://montsame.mn/2019-09-26)

бүтээн байгуулалтаа хийгээд дуусгалаа хэмээн түүнийг шавдуулсан бололтой. 2018 оны хавар Монголын эдийн засгийн форумд “Шанхайн хамтын ажиллагааны байгууллагатай хамтын ажиллагааг энэ жилдээ багтаан ахисан түвшинд аваачиж, илүү идэвхтэй хамтын ажиллагаанд шилжих хэрэгтэй байна. Ингэснээр Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн 8 улстай харилцах харилцаанд нэн таатай нөхцөл үүсэхийн зэрэгцээ олон жил яриад биеллээ олоогүй бүс нутгийн дэд бүтцэд холбогдох асуудал бодит ажил хэрэг болно”<sup>21</sup> хэмээн мэдэгдэв.

Тэгж хэлснийх нь дараа манай эрдэмтэд, сэтгүүлчид, ахмад дипломатчдын дунд өргөн хүрээтэй мэтгэлцээн өрнөж, ШХАБ-д жинхлүүлэх эсэх дээр маргаан дэгдсэн ба тэр маргааныг гярхай ажигласан Ерөнхийлөгч Х.Баттулга ГХЯ-нд хаалттай зөвлөлгөөн зохион байгуулж тал талын байр суурийг сонссон. Анхнаасаа буруу мэдээллээр өөрийг нь төөрөгдүүлсэн байна гэж үзсэн болов уу, тэр тухайгаа ч ШХАБ-ын дээд хэмжээний Циндаогийн уулзалтад үг хэлэхдээ битүү утгаар илэрхийлжээ. Үүнд “Монгол Улс Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад шат ахиулан оролцох боломжийг нарийвчлан судалж байгаа бөгөөд зохих хэлэлцүүлгийг улс төр, нийгмийн хүрээнд эхлүүлээд байна”<sup>22</sup> гэсэн ба түүнээсээ нэмж хальж элдэв мэдэгдэл (амлалт) хийгээгүй өнөө

хүрчээ. Ингэж мэдэгдэхдээ л ШХАБ нь эдийн засгийн интеграцын байгууллага болоосой гэсэн хүслээ хамт дайсан.

Харин ч нарийвчлан судлах явцдаа Гадаад харилцааны сайдын тушаалаар ажлын хэсэг байгуулуулж, ШХАБ-ын гишүүн орнуудаар явуулж судалгаа хийлгэх, дүгнэлт гаргуулах ажлыг Ерөнхийлөгч сэдсэн. Тэр ажлын хэсгийг зохион байгуулж, Хятад, Энэтхэгт ажиллахад нь голлон оролцсоны хувьд би асуудлыг нарийвчлан мэдэж, бичиж буй хэрэг.

2019 онд ШХАБ-ын дараагийн уулзалтад оролцоходоо ноён Х.Баттулга өмнөх байр сууриа дахин давтаж тайлбарласан. “Монгол Улс ШХАБ-д шат ахиулан оролцох боломжийг нарийвчлан судалж байгаа бөгөөд зохих хэлэлцүүлгийг улс төр, нийгмийн хүрээнд явуулж байгаа талаар Та бүхэнд мэдээлж байсан билээ. Монгол Улсыг ШХАБ-д элсүүлэх асуудлаар манай улсын дотоодод олон нийтийн санал бодол хуваагдмал байдалтай байна. ШХАБ-ын ажиглагч болон яриа хэлэлцээний түнш орнууд ба Нарийн бичгийн дарга нарын газрын хамтын ажиллагааг дунд хугацаанд хөгжүүлэх замын зургийн төслийг боловсруулж, ШХАБ-ын ажиглагчийн статусын журамд өөрчлөлт оруулах, ШХАБ-ын гишүүн болон ажиглагч орнуудтай хамтын ажиллагааг идэвхжүүлэн өргөжүүлэхээр төлөвлөж буйг талархан хүлээж авч байна”<sup>23</sup> – ердөө л энэ. Энд

21 Х.Баттулга: ШХАБ-тай хамтын ажиллагаагаа ахисан түвшинд гаргана, *news.mn/2018-05-22*

22 Х.Баттулга: Монгол Улс ШХАБ-ын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулахад бэлэн, *bloombergtv.mn/2018.06.10*

23 Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ШХАБ-ын өргөтгөсөн хуралдаанд оролцож үг хэллээ, *president.mn/2019/06/14*

жинхлүүлнэ гэсэн амлалт өгөөгүй.

Хамгийн сүүлчийн шинэхэн баримт. 2020 онд цар тахлаас үүдэлтэйгээр ШХАБ-ын дараагийн уулзалт цахимаар хуралдсан. Хурлыг ОХУ-ын Ерөнхийлөгч даргалсан. Түүнд ноён Х.Баттулга оролцохдоо ингэж хэлжээ. “Монгол Улс ШХАБ-ын төлөвшилтийг анхааралтай ажиглан, холбогдох судалгаануудыг хийж, эдийн засгийн болон хүмүүнлэгийн салбарын практик үйл ажиллагаанд ажиглагчийнхаа байр суурийг хадгалан, идэвхтэй оролцохыг эрмэлзэж байна. Монголын нутаг дэвсгэрээр дамжуулан ОХУ-аас БНХАУ руу байгалийн хий нийлүүлэх хоолой барих төсөлд тодорхой ахиц гарч буйд бид баяртай байна. Монгол, Орос, Хятад гурван улсын “Эдийн засгийн коридор”-ын чухал бүрэлдэхүүн хэсэг болох хурдны авто зам, төмөр замын төв, зүүн болон баруун коридорын төслүүдийг урагшлуулах нь Зүүн Ази ба Төв Азийн зах зээлийг холбож ШХАБ-ын хүрээний хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэх юм. Бидэнд ийм практик ач холбогдолтой, бодит үр дүнтэй үйл ажиллагаа чухал байгааг онцлон тэмдэглэе<sup>24</sup>” гэжээ.

Дараахан нь Монгол Улсын Шадар сайд ШХАБ-ын гишүүн орнуудын Засгийн газрын тэргүүн нарын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд цахимаар оролцож үг хэлэхдээ Төрийн тэргүүний үгийг бүр ч нотлож, Монгол Улс ШХАБ-

ын гишүүн орнуудтай эдийн засаг, хөдөө аж ахуй, дэд бүтэц, эрчим хүч, дамжин өнгөрөх тээвэр болон бусад салбарт идэвхтэй хамтран ажиллах, боломжтой төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах сонирхолтой байгаа ба Монголын нутаг дэвсгэрээр дамжуулан ОХУ-аас БНХАУ руу байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн үйл явц тодорхой ахицтай байгаад баяртай байгаагаа илэрхийлээд, Монгол, Орос, Хятад гурван улсын “Эдийн засгийн коридор”-ын чухал бүрэлдэхүүн хэсэг болох хурдны авто зам, төмөр замын төв, зүүн болон баруун коридорын төслүүд бүс нутгийн эдийн засгийн өсөлтийг түргэсгээд зогсохгүй, хамтын ажиллагаа, харилцан итгэлцлийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой гэдгийг онцлон тэмдэглэжээ<sup>25</sup>.

2020 оны намар манай Гадаад харилцааны сайд БНХАУ, ОХУ-ын Гадаад хэргийн сайд нартай Улаанбаатар, Москвад уулзсан. Тэр тухай ингэж ярьсан байх юм. “БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван И Монгол Улсад айлчлах үеэрээ ШХАБ-д “Монгол Улсыг элсээч” гэдэг санал тавьсан. Миний бие ОХУ-д албан айлчлал хийх үед тус улсын Гадаад хэргийн сайд С.В.Лавровтой уулзалт хийхэд энэ асуудлыг санал болгосон. Монгол Улс 2004 оноос тус байгууллагад ажиглагчийн статустай явж ирлээ. Өнөөдрийг хүртэл энэ байр суурь хэвээрээ байгаа. Хамгийн сүүлд 2018 оны 6 дугаар сард БНХАУ-д болсон дээд хэмжээний уулзалтын

24 Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ШХАБ-ын өргөтгөсөн цахим хуралдаанд оролцож үг хэллээ, *president.mn/2020/11/10*

25 Шадар сайд Я.Содбаатар ШХАБ-ын Засгийн газрын тэргүүн нарын хуралд оролцов, *montsame.mn/mn/2020-11-30*



үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга “ШХАБ-д шат ахиулан оролцох боломжтой. Үргэлжлүүлэн судална” гэдэг байр суурийг илэрхийлсэн. Өнөөдөр манай байр суурь энэ түвшинд байгаа гэдгийг тэмдэглэе<sup>26</sup>” гэжээ.

Тав дахь Ерөнхийлөгч Х.Баттулгатай Монгол Улсын Гадаад харилцааны дөрвөн сайд хамтран ажилласны сүүлчийнх болох хатагтай Б.Батцэцэг ОХУ-д албан ёсоор айлчлаад Оросын хэвлэлд ярилцлагад өгөхдөө “ШХАБ-ын тухай яриагаа үргэлжлүүлэе. Монгол Улс ШХАБ-ын ажиглагч орон. Харин энэ байгууллагад элсэх боломжтой юу?” гэсэн асуултад ингэж хариулжээ:–Монгол Улс ШХАБ-ын дэргэд ажиглагч болоод удаж байна. Бид дээд түвшний, Засгийн газрын түвшний болон холбогдох яамд, байгууллагуудын түвшний бүхий л уулзалтуудад оролцдог. ШХАБ-д Энэтхэг болон Пакистан улс элсэн орсноор энэхүү олон улсын байгууллагын ач холбогдол өссөн. Энэ байгууллагыг бид Төв Азийн бүс нутаг дахь хамтын ажиллагааны чухал гарцуудын нэг гэж үздэг. Түүнчлэн ШХАБ-ын үйл ажиллагааны хүрээнд хэрэгждэг худалдаа, эдийн засгийн төслүүдэд оролцдог. Бид худалдаа, эдийн засаг, хөдөө аж ахуй, тээвэр, дэд бүтцийн төслүүд, боловсрол, хүмүүнлэгийн салбарт ШХАБ-тай хамтран ажиллах сонирхолтой. Монгол Улс ШХАБ-ыг Төв Азитай хамтын ажиллагаа тогтоох сувгуудын нэг гэж үздэг. ШХАБ-д оролцогчдын

зүгээс манай улсыг энэ байгууллагын байнгын гишүүн болж, оролцоогоо нэмэгдүүлэх санал тавьдаг юм. Бид ШХАБ-ын суурь баримт бичгүүд болон энэ байгууллагын хүрээнд явуулдаг үйл ажиллагааг зохицуулах бусад баримт бичгүүдийг судалж байна. Сүүлийн жилүүдэд манай судлаачид, эрдэмтэд, төрийн шийдвэр гаргадаг хүмүүс энэ асуудлаар олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг явуулсны дараа энэ байгууллагад өнөөгийн статусаа хадгалах нь илүү оновчтой гэсэн дүгнэлтэд хүрсэн<sup>27</sup> гэжээ.

ШХАБ-тай холбогдуулаад өөр нэг эмзэг асуудал дагалддаг. Тэр нь ОДКБ буюу Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллагын үйл ажиллагаанд Монгол Улсыг гишүүнээр элсүүлэн нэгтгэх асуудал юм. Энэ тухай ОХУ-ын Гадаад хэргийн яамны Азийн асуудлыг хариуцсан нэгдүгээр газрын дарга Георгий Зиновьев ОХУ-ын Төрийн Думын Холбооны Зөвлөлд мэдээлж ингэж хэлж байв:–Монгол Улсыг ХАБГБ-д элсэн орохыг урьсан гэдгийг хэлэхийг хүсэж байна. Энэ нь Оросын Холбооны Улсын ашиг сонирхлын үүднээс чухал ач холбогдолтой чиглэл болж магадгүй юм. Монгол Улс энэхүү урилгад нааштайгаар хандаж буй бөгөөд тус улсын удирдагчдын зүгээс дэмжлэг хүлээж байгаа гэжээ.

Энэ асуудлаар “Оросын тал баримтлагч” ноён Х.Баттулга зарчмын зөв байр суурин дээрээ байсан ба орос нөхдөд итгэл төрүүлэх ямар нэг алхам илээр хийгээгүй болов уу гэж бодож

26 Н.Энхтайван: Гадаад харилцааны салбар улс төрөөс ангид ажиллана, *mfa.gov.mn*

27 Б.Батцэцэг: Бид ОХУ, БНХАУ-ын дунд аюулгүй байгаагаа мэдэрдэг, *sonin.mn/news/2021.06.02*

байна. Харин ч Гадаад харилцааны сайдаараа дамжуулан Монгол Улсын зарчмын байр суурийг илэрхийлсэн<sup>28</sup>. “Монгол Улс Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллагад элсэх үү?” гэсэн Оросын сурвалжлагчийн асуултад “Манай орны үндэсний аюулгүй байдлын концепцид бусад орнуудын зүгээс манай аюулгүй байдалд шууд аюул заналхийлэхгүй бол аливаа цэрэг, улс төрийн байгууллагад Монгол Улс оролцохгүй гэж заасан байдаг. Тиймээс бид Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага зэрэг цэрэг, улс төрийн байгууллагад элсэх шаардлагагүй” гэжээ.

Дүгнэж үзвээс, халаагаа өгөх гэж буй тав дахь Ерөнхийлөгчийг Оросын тал баримтлагч, Монголыг ШХАБ-д, улмаар ОДКБ-д барьж өгөх гэлээ, тэр нь бүтсэнгүй гэх шүүмжлэл, хардлага байдаг бол түүнд дээрх түүх бодит хариулт өгчихөж байгаа юм. Энд бүр маш тодорхой байр суурь харагдаж байна.

ШХАБ нь эдийн засгийн интеграцын байгууллага болохгүй л юм бол практик ач холбогдолгүй,

бодит үр дүнгүй, харин ч бүр гурван улсын “Эдийн засгийн коридор”-ын нэг механизм болох хэрэгтэй гээд бараг хэлчих шахжээ. Анхны төөрөгдөл (нэг талыг барьсан өрөөсгөл мэдээлэл очсон), дараа нь тэр төөрөгдлөө тун хурдан зассан, эргээд төвийг сахисан байр сууринаас ШХАБ-ыг олж харахыг хичээсэн, технократ өнцгөөс ШХАБ-ыг төлөвшөөсэй гэж хүссэн, тийм л түүх гурван жилд өрнөжээ. Харин дараагийн зургаа дахь Ерөнхийлөгч маань ШХАБ руу уухайлан шавдахгүй болов уу гэж итгэж байна. Монголын ард түмэнд биетэй бодитой очиж нялзах наалдах ямар ашиг, давуу талтай болоод бид шахуулаад байгаа билээ. Шахуулсаар шахуулсаар нэг өдөр жинхэлдэг, “Бид ШХАБ-ыг эв нэгдэл, харилцан итгэлцлийн үлгэр жишээ болгох ёстой” гэсэн Хятадын Төрийн тэргүүний мэргэн заалт ба түүний дэвшүүлсэн тэрхүү “ШХАБ-ын хүрээний найрамдал”-д харшилсан гэж үзэгдэн Монгол-Америкийн, Монгол-Японы стратегийн түншлэлээсээ салж, бүр гуравдагч хөршийн бодлогоо царцаах дээрээ тулсан эрсдэл үүрэх юм биш байгаа?

28 Б.Батцэцэг: Бид ОХУ, БНХАУ-ын дунд аюулгүй байдалд байгаагаа мэдэрдэг, *shuud.mn*, 2021-06-02

## Дүгнэлт

Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгч Х.Баттулга гадаад бодлогоо маш өвөрмөц арга барилаар (заримдаа стандарт бус) явуулсан гэж үзэж болно. Дээрх бүх түүх тэгж хэлээд байна. Тэрээр гурван салбарт амьдралаа зориулсан бие хүн. Уран зураач, самбо бөхийн дэлхийн аварга–тамирчин, бас бизнесч. Уран зургийн урлагийн нүдээр гадаад бодлогыг харахыг хичээсэн, бизнесийн гүйлгэн ухаан, дээр нь тамирчны хурд, тэвчээр, аль алин нь хослоод ирэхлээрээ маш прагматик, хувьсаж чаддаг, маневрлаж чаддаг гадаад бодлого харагдаж байна. Хэрэв ковидын цар тахал тулгараагүй бол илүү ихийг ч бүтээчих байлаа.

Гадаад харилцааны асар өргөн фронтыг ноён Х.Баттулга шүүмжлэлт өнцгөөс харсан. Аль нь хэрэгтэй, хэрэггүй юм гэдгийг ялгаж салгахыг хичээсэн. Үрэлгэн, хөл хөөрцөг болсон гадаад айлчлалуудаас татгалзсан. Олон талт форумыг хоёр талын харилцаанд ашиглаж болно гэдэг дээр чармайлт гаргасан.

Тэрээр явахдаа ингэж хэлсэн:– Миний урд талын Ерөнхийлөгчтэй харьцуулаад байж магадгүй. Байнга гадаадад яваад л, бөөнөөрөө яваад л. Тэр тал дээр би нэлээд татсан. Яагаад гэвэл дэлхий чинь хавтгай болчихсон, мэдээлэлтэй болчихсон. Монгол Улсын Ерөнхийлөгч юм уу, Ерөнхий сайд

гадаадад айлчиллаа гэхэд тэр улсын эдийн засаг, тэр хүн хэн бэ гэдэг цаас танилцуулгаараа нөгөө улсын уулзах гэж байгаа хүн дээр очдог. Ядуурал нь төд, авилгалд идэгдчихсэн, ийм баян орон мөртлөө ийм ядуу гэдэг танилцуулга урд нь ирчихсэн байхад үнэтэй зангиа зүүчихсэн, үнэртэй ус үнэртүүлсэн нэг тийм ганган хүн очоод яриад байхад чинь санаа зовно биз дээ гэсэн бодол миний урд талын Ерөнхийлөгчийн үед миний санаанд буудаг байсан. Тийм учраас гадаад харилцаан дээр сурталчилгаа явагдаагүй, ямар ч байсан хоёр хөрш, Энэтхэг, Америк, Европ гэсэн чиглэлээр айлчилж харилцаагаа барьж байсан<sup>29</sup> гэжээ. Өөрөө өөрийнхөө гадаад бодлогыг яг л дүгнэчихсэн байна.

Тэрээр Дипломат албыг ч өөрөөр харахыг хичээсэн. “Монголын ард түмэнд яг биетэй бодитой ашигтай ямар ажил хийж байна вэ Та нар?” гэх хатуу асуулт дипломатчдад тулгаж тавьсан. Дипломат алба бол тэгтлээ хошуурдаг, үхэлддэг, шагнал шахааны алба, албан тушаал биш гэдгийг ч хэд хэдэн удаа нотлоод тавьчихлаа.

Ямар ч гэсэн гадаад бодлого, гадаад харилцааг ноён Х.Баттулга өвөрмөц аргаар хөдөлгөж чадсан. Харин дараагийн зургаа дахь Ерөнхийлөгч нь хэрхэхийг харах л үлдлээ.

29 Танилц: Х.Баттулгын Ерөнхийлөгчийн хувиар өгсөн сүүлийн ярилцлагын онцлох эшлэлүүд, *ubn.mn/2021/06/06*

**Ашигласан материал:**

1. Ерөнхийлөгч Х.Баттулга: Олон жил яриа хэлцлийн түвшинд өрнөсөн ажлыг бодит болгохын төлөө Ши Жиньпин дарга, В.В.Путин Ерөнхийлөгч нартай ойр дотно, идэвхтэй хамтран ажиллах эрмэлзэл дүүрэн байна, *sonin.mn* agency, 2018-06-09
2. Орос, Хятадтай сайн хөршийн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ, *president.mn/2017/08/24*
3. Гуравдагч хөршийн худалдааны хуулийн төслийг АНУ-ын 117 дугаар Конгресст өргөн барилаа, *president.mn/2021/04/23*
4. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга: Тавантолгойн нүүрсийг төмөр замаар дамжуулж дэлхийн үнэ цэн рүү ойртуулах боломжийг харлаа, *president.mn/2017/09/06*
5. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга БНХАУ-ын дарга Ши Жиньпинтэй уулзлаа, *president.mn/5238/*
6. Гучин мянган хонь Монгол-Хятадын харилцаанд шинэ үүд хаалгыг нээж байна, *montsame.mn/241347*
7. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын дөрөв дэх удаагийн дээд хэмжээний уулзалтад оролцож үг хэллээ, *president.mn/4238/*
8. Х.Баттулга: Хүрэн нүүрсийг эрчим хүч болгож, экспортлох саналаа илэрхийллээ, *eagle.mn/ 2018-09-14*
9. Япон улсын Ерөнхий сайд Шинзо Абэ Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхав, *president.mn/5212/*
10. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, БНСУ-ын Ерөнхийлөгч Мүн Жэ Ин нар уулзав, *president.mn/1839/*
11. Монгол-Энэтхэгийн стратегийн түншлэлийг шинэ агуулгаар баяжуулав, *montsame.mn/2019-09-26*
12. Х.Баттулга: ШХАБ-тай хамтын ажиллагаагаа ахисан түвшинд гаргана, *news.mn/2018-05-22*
13. Х.Баттулга: Монгол Улс ШХАБ-ын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулахад бэлэн, *bloombergtv.mn/ 2018.06.10*
14. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ШХАБ-ын өргөтгөсөн хуралдаанд оролцож үг хэллээ, *president.mn/2019/06/14*
15. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ШХАБ-ын өргөтгөсөн цахим хуралдаанд оролцож үг хэллээ, *president.mn/2020/11/10*
16. Танилц: Х.Баттулгын Ерөнхийлөгчийн хувиар өгсөн сүүлийн ярилцлагын онцлох эшлэлүүд, *ubn.mn/2021/06/06*

17. Шадар сайд Я.Содбаатар ШХАБ-ын Засгийн газрын тэргүүн нарын хуралд оролцов, [montsame.mn/mn/2020-11-30](http://montsame.mn/mn/2020-11-30)
18. Д.Цогтбаатар: Том эрх ашгийг сөрснөөрөө би олон дайсантай болж байгаа, [ikon.mn/](http://ikon.mn/)
19. Н.Энхтайван: Гадаад харилцааны салбар улс төрөөс ангид ажиллана, [mfa.gov.mn](http://mfa.gov.mn)
20. Б.Батцэцэг: Бид ОХУ, БНХАУ-ын дунд аюулгүй байгаагаа мэдэрдэг, [sonin.mn/news/2021.06.02](http://sonin.mn/news/2021.06.02)
21. Б.Батцэцэг: Бид ОХУ, БНХАУ-ын дунд аюулгүй байдалд байгаагаа мэдэрдэг, [shuud.mn](http://shuud.mn), 2021-06-02
22. Өргөтгөсөн иж бүрэн түншлэлийн тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын Хамтарсан мэдэгдэл, [mfa.gov.mn](http://mfa.gov.mn), 2018-09-21
23. АНУ-ын Конгресс Монгол, Америкийн харилцааг бэхжүүлэх тухай тогтоол батлав, [mfa.gov.mn/](http://mfa.gov.mn/) 2020.12.08
24. Монгол, Японы Стратегийн түншлэлийг бэхжүүлэх мэдэгдэл гаргалаа, [news.mn/r/2059581/](http://news.mn/r/2059581/);
25. Монгол Улс, Монгол Улс, Япон Улсын стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг танилцуулав, [mfa.gov.mn/](http://mfa.gov.mn/) 2018.12.14
26. Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс, Япон Улсын хамтарсан мэдэгдэл, [mfa.gov.mn/](http://mfa.gov.mn/)  
[mn.usembassy.gov/mn/joint-statement-mongolia-japan-us-trilateral-meeting-mn/](http://mn.usembassy.gov/mn/joint-statement-mongolia-japan-us-trilateral-meeting-mn/)

## Foreign policy and its features of Mr. Battulga Khaltmaa, The Fifth President of Mongolia

***Bayarkhuu Dashdorj***

*Foreign policy expert, Ambassador Extraordinary and Plenipotentiary  
bayardevi@hotmail.com*

***Abstract:*** *It should be noted that this article is not written for Mr. Kh. Battulga, who resigned, but for the sixth President of Mongolia, Mr. U. Khurelsukh, who is the successor of Mr. Battulga and the Ministry of Foreign Affairs. Relying on the following facts, this article explains in detail how Mr. Battulga kept the consistency of foreign policy long pursued by the Mongolian “statehood” in a right, optimal and resource-saving manner while in office. The author hopes that this article will be read by the next President of Mongolia and his Office in the sense that Mongolia’s foreign policy has been consistent and the right beginning should be continued.*

***Keywords:*** *President of Mongolia, Kh.Battulga, foreign policy and use of multilateral forums in foreign relations*

<i>The day of submission:</i>	2021.06.03
<i>Completion of review:</i>	2021.06.15
<i>Final decision for acceptance:</i>	2021.06.19